

С.ИШДОРЖ
(1928-2005)

Монгол Улсын ууган дипломатчдын нэг, доктор Сосорын Ишдорж өвчний улмаас 2005 оны 10 дугаар сарын 11-ний өдөр хорвоогийн мөнх бусыг үзүүлж, үр хүүхэд, төрөл төрөгсөд, анд нөхөд бидэнд хүнд гарз тохиолоо.

Сосорын Ишдорж нь 1928 онд Увс аймгийн Завхан суманд төрж өссөн бөгөөд бага, дунд сургууль, Монгол Улсын Их Сургуульд суралцаж, улмаар Москва хотын Олон Улсын Харилцааны дээд сургуулийг түүхч-дипломатч мэргэжлээр төгссөн.

1953-аас 1997 онд Гадаад Харилцааны Яаманд дипломат ажилтан, МАХН-ын Төв Хорооны Гадаад Харилцааны хэлтэст орлогч эрхлэгч, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн даргын туслах, ШУА-ийн Дорно Дахины судлалын хүрээлэнд эрдэм шинжилгээний ахлах ажилтан зэрэг хариуцлагатай алба хашиж, төрөлх Монгол Улсынхаа төлөө чин шударгаар, идэвх зүтгэлтэй ажиллаж байсан халуун эх оронч хүн байлаа.

Тэрээр, Монгол Улсын гадаад харилцааг хөгжүүлэх, Нэгдсэн Үндэстний Байгууллагад Монгол Улс гишүүнээр элсэн ороход гар бие оролцон явж, Монгол-Америкийн харилцааны түүхийн асуудлыг ултай судалж, шинэ шатанд гаргахад хувь нэмрээ оруулсан түшээ, эрдэмтэн, багш, орчуулагч, нийтлэлч төдийгүй Монголын ардчилсан хөдөлгөөнийг анхнаас нь тууштай талархан дэмжигч байсан юм.

Бидний хайрт аав, өвөө, эрхэм анд Сосорын Ишдоржийн хөдөлмөрч, шударга, даруу зан, үнэт сургааль нь үр хүүхэд, ач зээ, найз нөхөд биднээр дамжин Монгол Улсын сайн сайхны төлөө ямагт сайн үйлээр илрэх болно.